# МОНГОЛ УЛСЫН
# ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
# ТУШААЛ

2023 оны 10 сарын 06 өдөр　　　　Дугаар А/106　　　　Улаанбаатар хот

Аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдын
чадамжийн хүрээг батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.10, 29.1.11 дэх заалт, 29.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн аудитын байгууллагын "Аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдын чадамжийн хүрээ"-г хавсралтаар батлсугай.

2."Аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдын чадамжийн хүрээ"-г хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж боловсруулан 2023 оны 12 дугээр сарын 11-ний өдрийн дотор батлуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар /Б.Бундхорол/-т үүрэг болгосугай.

3.Батлагдсан аргачилсан зөвлөмжийн дагуу "Аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдын чадамжийн хүрээ"-г үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажлыг төлөвлөн, гүйцэтгэлийг ханган ажиллахыг Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

4.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор /Ц.Наранчимэг/-т даалгасугай.

Д.ЗАНДАНБАТ

Z:\Tushaal\2023\Тушаал\ЕА-Ын А Тушаал\1006 KHBTG-1.Docx

0001[illegible]10897




# ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН АУДИТ ХИЙХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ АЛБАН ХААГЧДЫН

# ЧАДАМЖИЙН ХҮРЭЭ

2023 он

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2023 оны 10 дугаар сарын 06-ны
өдрийн А/106 тушаалын хавсралт

# АГУУЛГА


ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ ..........

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ ..........

УДИРТГАЛ .......... 1

НЭГ. ЧАДАМЖИЙН ХҮРЭЭНИЙ ТУХАЙ .......... 2

Чадамж.......... 2

Чадамжийн хүрээ.......... 2

Нийтлэг чадамж.......... 2

Мэргэжлийн чадамж .......... 2

ХОЁР. ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ЭРХЭМЛЭХ ЗАРЧИМ.......... 3

Төрийн аудитын байгууллагын алсын хараа:.......... 3

Төрийн аудитын байгууллагын эрхэм зорилго:.......... 3

Эрхэмлэх зарчим:.......... 3

ГУРАВ. ЧАДАМЖИЙН ХҮРЭЭНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ.......... 3

Чадамжийн хүрээний зорилго .......... 3

Чадамжийн хүрээний зорилтууд .......... 3

ДӨРӨВ. АУДИТ ХИЙХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ АЛБАН ХААГЧДЫН ЧАДАМЖИЙН ХҮРЭЭ 4

Аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдын чадамжийн хүрээний загвар .......... 4

Аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдын мэргэшлийн түвшин .......... 8

Аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдын чадамжийн тодорхойлолт, түүний шалгуур .......... 11

## ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ


Хүснэгт 1 Чадамжийн тодорхойлолт ........ 5
Хүснэгт 2 Албан тушаалын ангилал ........ 9
Хүснэгт 3. Удирдан зохион байгуулах чадамж ........ 11
Хүснэгт 4. Дүн шинжилгээ хийх чадамж ........ 13
Хүснэгт 5. Асуудал шийдвэрлэх чадамж ........ 14
Хүснэгт 6. Манлайлах чадамж ........ 15
Хүснэгт 7. Багаар ажиллах чадамж ........ 16
Хүснэгт 8. Харилцааны чадамж ........ 17
Хүснэгт 9. Мэргэжлийн болон салбарын хууль, эрх зүйн мэдлэг ........ 19
Хүснэгт 10. Мэргэжлийн стандартын мэдлэг ........ 20
Хүснэгт 11. Мэргэжлийн гадаад хэлний чадвар ........ 21
Хүснэгт 12. Мэдээллийн технологийн чадвар ........ 22
Хүснэгт 13. Аудитын сэдэв тодорхойлох ........ 23
Хүснэгт 14. Аудитыг төлөвлөх ........ 24
Хүснэгт 15. Аудитыг гүйцэтгэх ........ 26
Хүснэгт 16. Аудитын үр дүнг тайлагнах ........ 28
Хүснэгт 17. Аудитын мөрөөр хяналт тавих ........ 29
Хүснэгт 18. Аудитын чанарын хяналт ........ 30


## ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ


Зураг 1. Аудит хийх чиг үүрэг албан хаагчдын чадамжийн хүрээ ........ 4

# УДИРТГАЛ

Төрийн аудитын байгууллага төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг хууль ёсны дагуу арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад хяналт тавих, түүнчлэн төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх зорилготой. Энэ зорилгын хүрээнд чанартай, үр нөлөөтэй аудит хийхэд аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдын мэдлэг, ур чадвар нэн чухал юм.

Төрийн аудитын байгууллагын аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдыг чадавхжуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Сургалт, хөгжлийн стратеги, Чадамжийн хүрээ, Шаталсан сургалтын хөтөлбөрийг боловсруулж, тэрхүү хөтөлбөрийн дагуу цахим болон бусад сургалтын материалуудыг бэлтгэсэн.

Чадамжийн хүрээ нь Төрийн аудитын байгууллагын аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдад шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлагын шаардлагыг тодорхойлоход чиглэгдсэн. Чадамжийн хүрээ нь Төрийн аудитын байгууллагын аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчид өндөр хариуцлагатай байж чиг үүргээ үр нөлөөтэй, чанарын өндөр түвшинд гүйцэтгэхийн тулд мэргэжлийн ур чадвараа тогтмол хөгжүүлэх, бүтээмжээ дээшлүүлэхэд туслах юм.

Чадамжийн хүрээг холбогдох шалгуурын хамт нарийвчлан тодорхойлсноор гүйцэтгэлийг чанартай, өндөр түвшинд хүргэх боломжийг байгууллагад олгодог. Мөн байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, хэрэгцээ шаардлагад нийцсэн ур чадваруудыг тодорхойлох, сургалт, хөгжил, төрийн аудитын байгууллагын хүний нөөцийн залгамж халааг төлөвшүүлэх, чадамжид суурилсан төлөвлөлт, зохион байгуулалт хийхэд суурь болох баримт бичиг юм.

Чадамжийн хүрээг боловсруулахдаа олон улсын зөвлөхүүдтэй хамтран ажилласан бөгөөд Төрийн аудитын байгууллагын өнөөгийн тогтолцоо, хууль эрх зүйн орчин, онцлог байдал, харилцагч талуудын хүлээлтийг харгалзаж ИНТОСАИ-н “АДБ-ын төрийн аудитын мэргэжилтнүүдийн чадамжийн хүрээ” болон бусад улс орны сайн туршлагад тулгуурлав.

Энэхүү чадамжийн хүрээг Төрийн аудитын чиг үүргийг гүйцэтгэх, нийгмийн бүхий л салбарыг хамарсан өргөн хүрээний асуудалд үнэлэлт дүгнэлт өгөх мэдлэг, чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэх, сургалт, хөгжлийн хэрэгцээг тодорхойлох, сургалтын хөтөлбөр боловсруулахад суурь баримт бичиг болгон ашиглана.

## НЭГ. ЧАДАМЖИЙН ХҮРЭЭНИЙ ТУХАЙ

### *Чадамж*

Чадамж гэдгийг “ажлын амжилттай гүйцэтгэлд чухал ач холбогдолтой хэмжигдэх буюу ашиглаж болох хэрэгцээт мэдлэг, ур чадвар, хувь хүний шинж чанар” гэж тодорхойлсон[1].

### *Чадамжийн хүрээ*

Чадамжийн хүрээ гэдэг нь тодорхой төрөл чиглэлээр аудитыг гүйцэтгэхэд (санхүү, гүйцэтгэл, нийцэл) шаардагдах хувь хүний үндсэн болон мэргэжлийн чадамжийг нарийвчлан тодорхойлсон үзэл баримтлалын загвар юм. Чадамжийн хүрээ нь байгууллага болон ажилтнуудын ажлын гүйцэтгэл, үр дүнд чиглэсэн хамааралтай, хэрэглээ болохуйц, ойлгомжтой загвар байна.

Энэхүү Чадамжийн хүрээ нь Төрийн аудитын мэргэжилтэнд тавигдах нийтлэг ур чадвар (Удирдан зохион байгуулах, Дүн шинжилгээ хийх, Асуудал шийдвэрлэх, Манлайлах, Багаар ажиллах, Харилцах) болон мэргэжлийн тусгай ур чадварын ерөнхий тодорхойлолтыг агуулсан бөгөөд ур чадвар бүрийн шалгуур үзүүлэлтийг албан тушаалын шатлал бүрээр тодорхойлогдсон байна.

### *Нийтлэг чадамж*

Нийтлэг чадамж нь Төрийн аудитын байгууллагын бүх албан тушаалын ангилалд хамааралтай байх бөгөөд байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, үр дүнд хөтлөх, удирдах, зохион байгуулах, манлайлах, дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, багаар ажиллах, харилцааны чадамжтай байх явдал юм. Нийтлэг чадамж нь тухайн албан тушаалын шаардлага, үүрэг хариуцлагаас хамаарч шалгуур нь ялгаатай байж болно.

### *Мэргэжлийн чадамж*

Мэргэжлийн чадамж нь тодорхой ажил, үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай тусгай мэдлэг, ур чадвар, хандлагын нэгдэл байна. Энэ нь ихэвчлэн тухайн ажил, албан тушаалаас хамаарч ажил мэргэжил бүрээр ялгаатай тодорхойлогдоно. Тиймээс Төрийн аудитын байгууллагын аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдын мэргэжлийн чадамж нь тухайн албан тушаалын үндсэн чиг үүрэг, үр дүнтэй уялдаа бүхий мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хандлагаас бүрдэнэ.

[1] АДБ-ын Төрийн аудитын мэргэжилтнүүдийн чадамжийн хүрээ (INTOSAI 2019)

## ХОЁР. ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ЭРХЭМЛЭХ ЗАРЧИМ

### *Төрийн аудитын байгууллагын алсын хараа*

Монгол Улсын хөгжлийн бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн эдийн засаг, нийгмийн өндөр үр нөлөөтэй төрийн аудитыг гүйцэтгэж, арга зүй, технологи, үйл ажиллагаагаар бүс нутгийн хэмжээнд тэргүүлэх аудитын дээд байгууллага болно.

### *Төрийн аудитын байгууллагын эрхэм зорилго*

Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлж, харилцагч талуудын хамтын ажиллагааг сайжруулах замаар иргэдийн амьдралыг сайжруулна.

### *Эрхэмлэх зарчим*

- Хуулиа дээдлэх
- Мэргэшсэн байх
- Шударга ёсыг хангах
- Хараат бус, бие даасан байх
- Төрийн аудитын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, стандартад нийцэх
- Мэргэшсэн байх
- Ил тод, бодитой байх
- Мэдээллээр бүрэн хангагдах

## ГУРАВ. ЧАДАМЖИЙН ХҮРЭЭНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

### *Чадамжийн хүрээний зорилго*

Энэхүү чадамжийн хүрээ нь Төрийн аудитын байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, эрхэмлэх зүйл болон стратегийн зорилгод нийцсэн төрийн аудитыг өндөр чанартай, үр дүнтэй гүйцэтгэхэд шаардлагатай чадамжтай мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх, аудитын чиг үүрэг бүхий албан хаагчдын чадамжийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэнэ.

### *Чадамжийн хүрээний зорилтууд*

- Төрийн аудитын чанар, үр нөлөөг нэмэгдүүлэх болон байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, стратегийн зорилтуудыг хангахад шаардлагатай чадамжтай хүний нөөцийг бүрдүүлэхэд суурь нөхцөлийг бий болгох;

- Төрийн аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдын чадамжийг уламжлалт болон орчин үеийн дэвшилтэт арга хандлагуудаар тасралтгүй хөгжүүлэх, түүний хэрэгцээг тодорхойлоход суурь болох;

- Төрийн аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдын чадамжийг хөгжүүлэх сургалт, хөгжлийн стратегийг хэрэгжүүлэхэд тулгуур баримт бичиг болох.

## ДӨРӨВ. АУДИТ ХИЙХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ АЛБАН ХААГЧДЫН ЧАДАМЖИЙН ХҮРЭЭ

Төрийн аудитын байгууллагын аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдын чадамжийн хүрээ нь Төрийн аудитын байгууллагын өнөөгийн тогтолцоо, онцлог байдал, хууль, эрх зүйн орчны шаардлага, харилцагч талуудын хүлээлтийг харгалзсан, ИНТОСАИ-н Аудитын дээд байгууллагуудын төрийн аудитын мэргэжилтнүүдийн чадамжийн хүрээг тодорхойлсон болон бусад улс орны сайн туршлагад тулгуурласан байна.

### *Аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдын чадамжийн хүрээний загвар*

Төрийн аудитын байгууллагын аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагч нь ***нийтлэг 6 чадамж*** болон ***мэргэжлийн 10 чадамжийг*** эзэмшсэн, өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй, төрийн аудит хийх чиг үүргээ чанартай, үр дүнтэй гүйцэтгэх мэдлэг, ур чадвартай, төрийн албан хаагчийн болон мэргэжлийн өндөр ёс зүй, хандлагатай албан хаагч байна. Үүнд:

- **Нийтлэг чадамж:** Аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагч нь Төрийн аудитын үндсэн чиг үүргийг үр дүнтэй, чанартай гүйцэтгэж, төрийн аудитын байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, хөгжлийн бодлого, стратегийг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулахын тулд хариуцсан ажлаа үр дүнтэй удирдан зохион байгуулах, нийгмийн бүхий л салбарыг хамарсан асуудалд дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, манлайлах, багаар ажиллах, харилцагч талуудтай үр дүнтэй харилцах харилцааны ур чадвартай байна.
- **Мэргэжлийн чадамж:** Аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагч нь Төрийн аудитын үндсэн зорилго, чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах мэргэжлийн мэдлэг, аудитыг чанартай гүйцэтгэх мэргэжлийн ур чадвартай, өндөр ёс зүйтэй, мэргэжлийн мэдлэг, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх чадвартай байна.

Төрийн аудитын байгууллагын аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдын нийтлэг болон мэргэжлийн чадамжийн хамрах хүрээг дараах зураглалаар харуулж байна. (Зураг 1)

*Зураг 1. Аудит хийх чиг үүрэг албан хаагчдын чадамжийн хүрээ*



Төрийн аудитын байгууллагын аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдын нийтлэг ба мэргэжлийн чадамжийн ерөнхий тодорхойлолт дараах агуулгыг хадгалсан байна. (Хүснэгт 2)

*Хүснэгт 1. Чадамжийн тодорхойлолт*

| Албан тушаалын бүлэг | Чадамжийн бүлэг | Дэд чадамж | Тодорхойлолт |
|---|---|---|---|
| **Бүх албан тушаалд хамааралтай** | **Нийтлэг чадамж** | 1. Удирдан зохион байгуулах | Хариуцлагатай байж зорилгодоо үр дүнтэй хүрэх, гүйцэтгэлийг сайжруулах, байгууллагыг хөгжүүлэхийн тулд хэрхэн хамтран ажиллах, ажлаа сайн төлөвлөх, нөөц боломжийг зөв ашиглах, хуваарилах замаар байгууллагын үйл ажиллагааг оновчтой удирдан зохион байгуулах, хүлээн зөвшөөрөгдөх чадвар юм. |
| | | 2. Дүн шинжилгээ хийх | Баримт нотолгоонд тулгуурлан гол асуудлыг тодорхойлох, холбогдох мэдээллийг боловсруулах, тухайн асуудлын чиг хандлага ба онцлогийг мэдэж, шалтгаан үр дагаврыг тодорхойлох, учир холбогдлыг эргэцүүлэн бодох, шүүн тунгаах, агуулгыг тодорхойлох, үзэл баримтлал боловсруулах, мэдлэг болон мэдрэмжээ ашиглах чадвар юм. |
| | | 3. Асуудал шийдвэрлэх | Байгууллага болон хувь хүний асуудлыг шийдвэрлэхэд баримт нотолгоог ул суурьтай үндэслэлтэй гаргаж ашиглах, асуудлыг сайн, тунгаан ойлгож оношлох, туршлага, сургамжийг харгалзан, амьдралд нийцтэй шийдвэр гаргах чадвар юм. |
| | | 4. Манлайлах | Ажилтнууд урам зоригтой хичээнгүйлэн, өндөр бүтээмжтэй ажиллах, үнэнч шударгаар харилцах, нээлттэй, ил тод байх орчныг бий болгож улмаар бүх хүнд шударга, үнэнч хандаж ёс зүйн дүрмийг сурталчлан дагаж мөрдөх, өөрөөрөө үлгэрлэх замаар бусдад зэргээр нөлөөлөх, Төрийн аудитын байгууллагын стратеги, бодлогын |

| | | | |
|---|---|---|---|
| | | | зорилгыг тодорхойлох, боловсруулах, хэрэгжүүлэх, биелэлтийг хангах харилцааны явцад байгууллага, албан хаагчид, иргэдийн дэмжлэг, оролцоог манлайлах чадвар юм. |
| | | 5. Багаар ажиллах | Мэдээлэл, санаа оноо, нөөц, дэмжлэгийг бусадтай хуваалцаж ажиллах, байгууллагын болон багийн нэгдмэл зорилгод хүрэхэд үр дүнтэй хамтран ажиллах чадвар юм. |
| | | 6. Харилцааны чадвар | Төрийн аудитын үндсэн чиг үүргээ чанартай гүйцэтгэхийн тулд байгууллагын гадна болон дотоод орчинд удирдлага, хамтран ажиллагсад, харилцагч талуудтай мэдээлэл солилцох, өөрийгөө илэрхийлэх үр дүнтэй харилцах чадвар юм. |
| **Аудит хийх чиг үүрэг бүхий албан тушаалд хамааралтай** | **Мэргэжлийн мэдлэг** | 7. Мэргэжлийн болон салбарын хууль эрх зүйн мэдлэг | Аудит хийх чиг үүргийг гүйцэтгэхийн тулд нийгмийн бүхий л салбарын хүрээнд үнэлэлт дүгнэлт өгөх мэргэжлийн болон салбарын холбогдох хууль эрх зүйн актыг ашиглах чадвар юм. |
| | | 8. Мэргэжлийн стандартын мэдлэг | Хууль тогтоомжид заасан аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС болон түүнд нийцүүлэн боловсруулсан үндэсний стандарт, заавар, удирдамжийн мэдлэг, аудитын үйл ажиллагаанд ашиглах чадвар юм. |
| | | 9. Мэргэжлийн гадаад хэлний чадвар | Төрийн аудитын арга зүй, стандартын шинэчлэл, олон чиг хандлагад нийцсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвараа хөгжүүлж чадахуйц гадаад хэлний мэдлэгтэй байх чадвар юм. |
| | | 10. Мэдээллийн технологийн чадвар | Орчин үеийн мэдээллийн технологийн орчинд ажиллах, аудитын үйл ажиллагаанд үр дүнтэй ашиглах чадвар юм. |
| | **Мэргэжлийн ур чадвар** | 11. Аудитын сэдэв тодорхойлох | Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үнэ цэнэ нэмэх төрийн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | аудитыг гүйцэтгэхийн тулд ач холбогдолтой, чухал сэдвүүдийг тодорхойлох, сонгох чадвар юм. |
| | | 12. Аудитыг төлөвлөх | Төрийн аудитыг үр дүнтэй гүйцэтгэх орчин нөхцөлийг судалж, эрсдэлд суурилсан аудитыг төлөвлөх, аудитын цар хүрээ, хэрэгжүүлэх горим сорилыг тодорхойлох, нөөцийн төлөвлөлтийг оновчтой хийх чадвар юм. |
| | | 13. Аудитыг гүйцэтгэх | Гүйцэтгэж буй аудитын үр дүнгийн талаар үнэн зөв, бодитой дүгнэлт, зөвлөмж бэлтгэхийн тулд холбогдох аудитын горим сорилыг хэрэгжүүлэх замаар нотлох зүйл олж авах, хэрэгжүүлсэн горим болон олж авсан нотлох зүйлсийн хангалттай, зохистой байдалд дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг зохих ёсоор баримтжуулах чадвар юм. |
| | | 14. Аудитын үр дүнг тайлагнах | Аудитын үр дүнг холбогдох аудитын стандартын шаардлагад нийцүүлэн бодитой, үндэслэлтэй, иж бүрэн, нягт нямбай, ойлгомжтой, батлагдсан загвар, стандартын дагуу бэлтгэж, харилцагч талуудад тайлагнах чадвар юм. |
| | | 15. Аудитын мөрөөр хяналт тавих | Харилцагч талуудтай хамт аудитын үр дүнг эргэн харж, хяналт тавих төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх, аудитаас гаргасан зөвлөмж, шийдвэрийн хэрэгжилтийг хянах чадвар юм. |
| | | 16. Аудитын чанарын хяналт хийх | Чанарын хяналт хийх зорилгоор холбогдох стандарт, дүрэм журам зохистой хэрэгжсэн гэдгийг үнэлэх, аудитын хэрэгжүүлсэн горим, гүйцэтгэлд үнэлэлт дүгнэлт өгөх, сайжруулах зөвлөмж өгөх чадвар юм. |

*Аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдын мэргэшлийн түвшин*

Мэргэшлийн түвшин нь ажлын байранд гүйцэтгэж буй ажлын зорилт, даалгавар, үүрэг хариуцлагын хуваарилалт болон нарийн төвөгтэй байдал, ажлын байрны чиг үүрэгтэй уялдсан, албан тушаалын байдлаар тодорхойлогдох бөгөөд энэ нь байгууллагын албан тушаалын ангилал, шатлалтай нягт уялдаатай байна.

Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын албан тушаалаас хамаарч чадамжийн хүрээ нь аудит хийх чиг үүрэг бүхий албан тушаал бүрээр тодорхойлсноор мэргэшлийн түвшин нь ажлын нарийн төвөгтэй байдал, хамрах хүрээ, хариуцлагын ялгааг харуулна.

Төрийн аудитын тухай хуулийн 25 дугаар зүйлд зааснаар Төрийн аудитын байгууллагын албан тушаал нь дараах 6 ангилалтай.

1) Төрийн аудитын тэргүүн түшээ
2) Төрийн аудитын шадар түшээ
3) Төрийн аудитын итгэмжит түшээ
4) Төрийн аудитын зөвлөх түшээ
5) Төрийн аудитын ахлах түшээ
6) Төрийн аудитын түшээ

Төрийн аудитын байгууллагын аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдын чадамжийн хүрээ нь Төрийн аудитын итгэмжит түшээ, зөвлөх түшээ, ахлах түшээ, түшээ гэсэн ангилалтай хамааралтай байна.

Монгол Улсын Төрийн аудитын байгууллагын аудит хийх чиг үүрэг бүхий албан хаагчдын эрхлэх асуудал, ажлын цар хүрээнд суурилсан мэргэжил, мэргэшлийн ялгамжтай байдлыг албан тушаалын ангиллаар тодорхойлно. (Хүснэгт 2)

# АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ

*Хүснэгт 2.*

| Албан тушаалын ангилал | Төрийн аудитын түшээ | Төрийн аудитын ахлах түшээ | Төрийн аудитын зөвлөх түшээ | Төрийн аудитын итгэмжит түшээ |
|---|---|---|---|---|
| **Албан тушаалын нэр** | *Аудитор* | *Ахлах аудитор* | *Аудитын менежер* | *Тэргүүлэх аудитор* |
| **Боловсролын шаардлага** | Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй | Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй | Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй | Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй |
| **Мэргэжлийн шаардлага** | - Нягтлан бодох бүртгэл, татвар /0411/;<br>- Санхүү, банк, даатгал /0412/;<br>- Эдийн засаг /0311/;<br>- Эрх зүй /0421/;<br>- Бусад. | - Нягтлан бодох бүртгэл, татвар /0411/;<br>- Санхүү, банк, даатгал /0412/;<br>- Эдийн засаг /0311/;<br>- Эрх зүй /0421/;<br>- Бусад. | - Нягтлан бодох бүртгэл, татвар /0411/;<br>- Санхүү, банк, даатгал /0412/;<br>- Эдийн засаг /0311/;<br>- Эрх зүй /0421/;<br>- Бусад. | - Нягтлан бодох бүртгэл, татвар /0411/;<br>- Санхүү, банк, даатгал /0412/;<br>- Эдийн засаг /0311/;<br>- Эрх зүй /0421/;<br>- Менежмент ба удирдахуй /0413/;<br>- Бусад. |
| **Мэргэшил** | - Төрийн албанд мэргэшүүлэх эсхүл түүнтэй адилтгах сургалтад хамрагдаж төгссөн байх,<br>- Мэргэшсэн нягтлан бодогч эсвэл мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх. | - Ахлах түшмэл эсхүл түүнтэй адилтгах сургалтад хамрагдаж төгссөн байх,<br>- Мэргэшсэн нягтлан бодогч эсвэл мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх. | - Эрхэлсэн түшмэл эсхүл түүнтэй адилтгах сургалтад хамрагдаж төгссөн байх,<br>- Мэргэшсэн нягтлан бодогч эсвэл мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх,<br>- АЗ сертификаттай | - Тэргүүн түшмэл эсхүл түүнтэй адилтгах сургалтад хамрагдаж төгссөн байх,<br>- Мэргэшсэн нягтлан бодогч эсвэл мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх,<br>- АЗ сертификаттай |
| **Туршлага** | - Мэргэжлээрээ 4 жил ажилласан туршлагатай байх. | - Төрийн албанд 6-аас доошгүй жил,<br>- Үүнээс төрийн аудитын түшээ ангиллын албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх. | - Төрийн албанд 8-аас доошгүй жил,<br>- Үүнээс төрийн аудитын ахлах түшээ эсхүл төрийн захиргааны ахлах түшмэл болон түүнтэй адилтгах ангиллын албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх. | - Төрийн албанд 12-оос доошгүй жил,<br>- Үүнээс төрийн аудитын зөвлөх түшээ эсхүл төрийн захиргааны эрхэлсэн түшмэл болон түүнтэй адилтгах ангиллын албан тушаалд 6-аас доошгүй жил ажилласан байх. |
| **Албан тушаалын үндсэн зорилго (Ажлын цар хүрээ)** | - Төрийн аудитын тухай хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг баримтлан шууд тайлагнах ажилд хамаарах аудитыг дагнан эсхүл нийцлийн аудиттай хослуулан гүйцэтгэх,<br>- Аудитын сонгогдсон сэдэв, төлөвлөлтөд судалгаа хийж, эрсдэлийг тодорхойлох,<br>- Батлагдсан сэдэв, хуваарийн дагуу хийх шууд тайлагнах | - Төрийн аудитын тухай хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг баримтлан шууд тайлагнах ажилд хамаарах аудитыг дагнан эсхүл нийцлийн аудиттай хослуулан гүйцэтгэх,<br>- Аудитын сонгогдсон сэдэв, төлөвлөлтөд судалгаа хийж, эрсдэлийг тодорхойлох,<br>- Аудитын багийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион | - Төрийн аудитын тухай хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг баримтлан шууд тайлагнах ажилд хамаарах, аудитыг дагнан эсхүл нийцлийн аудиттай хослуулан төлөвлөж, гүйцэтгэх үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэх,<br>- Аудитын багийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хууль, | - Төрийн аудитын тухай хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг баримтлан шууд тайлагнах ажилд хамаарах аудитыг дагнан эсхүл нийцлийн аудиттай хослуулан гүйцэтгэх,<br>- Аудитын сонгогдсон сэдэв, төлөвлөлтөд судалгаа хийж, эрсдэлийг тодорхойлох,<br>- Нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | ажилд хамаарах аудитын төлөвлөгөө, төсөв, зардал, хөтөлбөрийг батлуулах, хэрэгжүүлэх, дүнг үр дүнг тайлагнах. | байгуулж, анхан шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэх чиг үүргийг гүйцэтгэж тайлагнах. | эрх зүйн дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг хангуулах,<br>- Захиргааны акт, шийдвэр гаргах үйл ажиллагаанд хяналт тавих, санал зөвлөмж хүргүүлэх, нэгжид хууль зүйн дэмжлэг үзүүлэх. | - Батлагдсан сэдэв, хуваарийн дагуу хийх шууд тайлагнах ажилд хамаарах аудитын төлөвлөгөө, төсөв, зардал, хөтөлбөрийг батлуулах, чанарын хяналт тавих. |

## УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ ЧАДАМЖ

*Хүснэгт 3.*

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Чадамжийн бүлэг** | **Нийтлэг чадамж** | | | |
| **Дэд чадамж** | **Удирдан зохион байгуулах** | | | |
| **Чадамжийн тодорхойлолт** | Хариуцлагатай байж зорилгодоо үр дүнтэй хүрэх, гүйцэтгэлийг сайжруулах, байгууллагыг хөгжүүлэхийн тулд хэрхэн хамтран ажиллах, ажлаа сайн төлөвлөх, нөөц боломжийг зөв ашиглах, хуваарилах замаар байгууллагын үйл ажиллагааг оновчтой удирдан зохион байгуулах, хүлээн зөвшөөрөгдөх чадвар юм. | | | |
| **Албан тушаал** | *Аудитор* | *Ахлах аудитор* | *Аудитын менежер* | *Тэргүүлэх аудитор* |
| **Албан тушаалын ангилал** | *Төрийн аудитын түшээ* | *Төрийн аудитын ахлах түшээ* | *Төрийн аудитын зөвлөх түшээ* | *Төрийн аудитын итгэмжит түшээ* |
| **Шалгуур үзүүлэлт** | – Хийх ажил үүргээ тодорхой мэддэг, хэрхэн үр дүнтэй биелүүлэхээ мэддэг,<br>– Ахлах түвшний албан хаагчдыг баримт нотолгоо бүхий мэдээллээр хангадаг,<br>– Төлөвлөсөн зорилго, зорилтод хүрэхийн төлөө ажилладаг,<br>– Өөрийн нөөц, боломжийг бодитой, найдвартай удирдан зохион байгуулдаг,<br>– Ажил сайжруулах ба асуудал шийдвэрлэх санал гаргадаг,<br>– Аливааг зохион байгуулахдаа эрсдэлийг урьдчилан харж, түүнээс сэргийлдэг,<br>– Санал хүсэлтэд нээлттэй хандаж, хариу өгдөг,<br>– Төлөвлөсөн үр дүнд хүрэхэд хамтран ажиллагсдыг урамшуулан, ажлаа үр дүнтэй зохион байгуулдаг, | – Ажил үүргийн зорилгоо тодорхой, бодитой тодорхойлдог,<br>– Ажлыг төлөвлөсөн хугацаанд, чанартай гүйцэтгэдэг,<br>– Өөрийн удирдлага, чиглүүлэг дор ажилладаг аудиторууд нь ажил үүргээ бүрэн ойлгосон, зөв эрэмбэлсэн эсэхэд анхаарал хандуулдаг,<br>– Эрсдэл болон бэрхшээлтэй асуудлыг оновчтой удирдан зохион байгуулдаг,<br>– Ажлын төлөвлөгөөнөөс гарах үр дүнг зөв сайн тодорхойлж чаддаг,<br>– Хамтран ажиллагсад, харилцагч талуудтай адил тэгш, ялгаваргүй ханддаг,<br>– Ажил хэргээ нээлттэй, шударгаар тайлагнадаг,<br>– Үр дүн, үр дагаврын төлөө хариуцлага хүлээдэг,<br>– Өөрийн болон удирдлагад нь ажилладаг аудиторуудын ажлын гүйцэтгэлийг сайжруулахад дэмжлэг | – Ажлаа эрэмбэлж, төлөвлөн хэрэгжүүлдэг бөгөөд эрсдэлийг урьдчилан харж бууруулдаг,<br>– Ажлын арга барил, үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулдаг,<br>– Хүний нөөцийн төлөвлөлтийг хамгийн үр ашигтай байхаар зохион байгуулдаг,<br>– Учирч болохуйц хямрал, зөрчилдөөнийг урьдчилан тооцоолж, удирдан зохион байгуулдаг,<br>– Хамт олон, удирдлагууд, харилцагч талуудтай нээлттэй харилцдаг,<br>– Ажлыг үр дүнтэй явуулахын тулд гүйцэтгэлийг тогтсон хугацаанд хянаж нягтлан эргэн хардаг,<br>– Харилцагч талуудыг тодорхойлж, төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн явцад оролцоог хангаж зөвлөдөг, | – Байгууллагын ажил, үйл ажиллагаа бүрийг бүхэлд нь мэддэг, үйл явц, үр дүнг хянадаг,<br>– Газар, нэгжийн үйл ажиллагаар байгууллагын стратеги зорилт руу чиглүүлдэг,<br>– Гарсан алдаанд хариуцлага хүлээдэг, асуудлыг шийдвэрлэдэг,<br>– Албан хаагчдадаа урам өгдөг,<br>– Байгууллагын бодлого, стратегийг хэрэгжүүлж, үр нөлөөг хянадаг,<br>– Хамтын ажиллагааг дэмждэг, асуудал бэрхшээлийг урьдчилан таамаглаж ил тод, ойлгомжтой шийдвэрлэдэг,<br>– Харилцагч талуудтай үр дүнтэй харилцаатай байж, тэдний хэрэгцээ, сонирхлыг анхаардаг,<br>– Боломжийг тэгш хүртээдэг, ёс зүйтэй, олон талт байдлыг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | – Ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг. | үзүүлдэг, сайжруулах тодорхой аргуудыг ашигладаг,<br>– Үйл ажиллагаандаа хяналт шинжилгээ, үнэлгээ хийдэг,<br>– Ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг. | – Ёс зүйн хэм хэмжээг сахиж адил тэгш, олон талт байдлыг нягт баримталдаг. | эрхэмлэдэг удирдах албан тушаалтны дүр төрхийг илэрхийлэгч. |

## ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЧАДАМЖ

*Хүснэгт 4.*

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Чадамжийн бүлэг** | **Нийтлэг чадамж** | | | |
| **Дэд чадамж** | **Дүн шинжилгээ хийх** | | | |
| **Чадамжийн тодорхойлолт** | Баримт нотолгоонд тулгуурлан гол асуудлыг тодорхойлох, холбогдох мэдээллийг боловсруулах, тухайн асуудлын чиг хандлага ба онцлогийг мэдэж, шалтгаан үр дагаврыг тодорхойлох, учир холбогдлыг эргэцүүлэн бодох, шүүн тунгаах, агуулгыг тодорхойлох, үзэл баримтлал боловсруулах, мэдлэг болон мэдрэмжээ ашиглах чадвар юм. | | | |
| **Албан тушаал** | *Аудитор* | *Ахлах аудитор* | *Аудитын менежер* | *Тэргүүлэх аудитор* |
| **Албан тушаалын ангилал** | *Төрийн аудитын түшээ* | *Төрийн аудитын ахлах түшээ* | *Төрийн аудитын зөвлөх түшээ* | *Төрийн аудитын итгэмжит түшээ* |
| **Шалгуур үзүүлэлт** | – Мэдээллийн үнэн зөвийг байнга магадалж шалгадаг,<br>– Цуглуулсан мэдээлэл, тоо баримтыг тайлбарлахдаа баримт материал, нотолгоо ашигладаг,<br>– Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад анхаарал хандуулдаг,<br>– Болзошгүй эрсдэлийг үнэлж даван туулах шийдлийг санал болгодог,<br>– Үйл ажиллагааны шууд болон шууд бус үр дагаврыг тооцоолдог,<br>– Нарийн төвөгтэй мэдээллийг үнэн зөв, ойлгомжтой тайлбарладаг,<br>– Мэдээллийн нууцлалыг ойлгож хүндэтгэлтэй ханддаг,<br>– Өгөгдлийн шинжилгээний хэрэгслүүдийг ашиглан дүн шинжилгээ хийдэг. | – Мэдээллийн боломжит бүх эх үүсвэрийг ашигладаг,<br>– Нарийн төвөгтэй мэдээлэлд дүн шинжилгээ хийж зөв шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлдэг,<br>– Шийдвэрийн үр дагаврыг тооцоолж, болзошгүй эрсдэлийг тодорхойлж, түүнийг давах шийдлийг зөвлөдөг,<br>– Нотолгоонд суурилсан дүн шинжилгээ, судалгаа хийдэг,<br>– Бүртгэлийг үнэн зөв, хэрэглэгдэхүйц байдлаар хөтөлдөг,<br>– Ажилдаа орчин үеийн мэдээллийн технологийг ашигладаг,<br>– Тоон мэдээллийн утга, агуулгыг ойлгодог,<br>– Өөрийн шүүн тунгаах, бүтээлч сэтгэлгээг сайжруулахад суралцдаг,<br>– Эх сурвалж нь тодорхой, үнэн бодит мэдээллийг хуваалцдаг,<br>– Өгөгдлийн шинжилгээний хэрэгслүүдийг ашиглан дүн шинжилгээ хийдэг. | – Хэрэгжихүйц зөвлөгөө өгөхийн тулд нарийн төвөгтэй мэдээллийг маш сайн ойлгодог,<br>– Ажил, үйлчилгээг сайжруулах, шинэ санаачилгыг дэмжихийн тулд баримт, нотолгоотой мэдээлэл ашигладаг,<br>– Аливаа санал боловсруулахдаа дүн шинжилгээ, хяналт, үнэлгээ, харьцуулсан судалгаанд үндэслэдэг,<br>– Асуудлыг өргөн хүрээнд авч үздэг бөгөөд оролцогч талуудын үзэл бодол, баримт нотолгоог харгалздаг,<br>– Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын хэм хэмжээг нягт баримталдаг,<br>– Өгөгдлийн шинжилгээний хэрэгслүүдийг ашиглан дүн шинжилгээ хийдэг. | – Хэрэгжихүйц зөвлөгөө өгөхийн тулд нарийн төвөгтэй мэдээллийг сайн ойлгож ашигладаг,<br>– Үндэсний хэмжээний зорилтод дэмжлэг үзүүлэхийн тулд боломж ба эрсдэлийг харж чаддаг,<br>– Аливаа мэдээллийг үр дүнтэй ашиглахын тулд мэдрэмжтэй, бүтээлч ханддаг,<br>– Бодлого боловсруулахдаа дүн шинжилгээ, хяналт, үнэлгээ, харьцуулсан судалгаанд үндэслэдэг,<br>– Баталгаатай, хэрэгжүүлж болохуйц зөвлөгөө өгөхийн тулд нөхцөл байдлыг бодитоор харж шүүн тунгаадаг,<br>– Бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэхдээ баримт, нотолгоо, мэдээллийг өргөн ашигладаг. |

## АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭХ ЧАДАМЖ

*Хүснэгт 5.*

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Чадамжийн бүлэг** | **Нийтлэг чадамж** | | | |
| **Дэд чадамж** | **Асуудал шийдвэрлэх** | | | |
| **Чадамжийн тодорхойлолт** | Байгууллага болон хувь хүний асуудлыг шийдвэрлэхэд баримт нотолгоог ул суурьтай үндэслэлтэй гаргаж ашиглах, асуудлыг сайн, тунгаан ойлгож оношлох, туршлага, сургамжийг харгалзан, амьдралд нийцтэй шийдвэр гаргах чадвар юм. | | | |
| **Албан тушаал** | *Аудитор* | *Ахлах аудитор* | *Аудитын менежер* | *Тэргүүлэх аудитор* |
| **Албан тушаалын ангилал** | *Төрийн аудитын түшээ* | *Төрийн аудитын ахлах түшээ* | *Төрийн аудитын зөвлөх түшээ* | *Төрийн аудитын итгэмжит түшээ* |
| **Шалгуур үзүүлэлт** | – Асуудлын шалтгаануудыг ялгаж салган харж чаддаг,<br>– Асуудлыг урьдчилан таамаглаж, зөв тодорхойлдог,<br>– Өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэр гаргадаг,<br>– Асуудлын цар хүрээг ойлгож, шаардлагатай бол тусламж, зөвлөгөө эрэлхийлдэг,<br>– Асуудал тодорхойлж, шийдвэрлэхэд бусадтай хамтран ажилладаг,<br>– Шийдэл санал болгодог,<br>– Асуудлыг шийдвэрлэх хууль эрхзүйг баримтлан, ёс зүйтэй шийдвэрлэдэг,<br>– Үүрэг хариуцлагын хүрээнд хуульд нийцсэн, баталгаатай, хэрэгжихүйц шийдвэр гаргадаг. | – Асуудлыг зөв тодорхойлж, боломжит шийдэл олдог,<br>– Асуудал шийдвэрлэхтэй холбогдох бүх баримт материалыг авч үздэг,<br>– Асуудлыг шийдвэрлэхдээ хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй эсэхийг нягталдаг,<br>– Шийдлийг олохдоо хууль дүрэм журам, ёс зүйтэйгээр тунгаадаг,<br>– Хамгийн оновчтой шийдэл олохын тулд бусадтай хамтардаг, зөвлөлддөг,<br>– Тодорхой, эргэлзээгүй, баталгаатай шийдвэр гаргадаг,<br>– Асуудал дахин давтагдах эрсдэлээс сэргийлж гаргасан шийдвэрээ эргэн харж хянадаг,<br>– Асуудлыг хэлэлцэж оновчтой шийдэл гаргадаг тогтолцоо бий болгодог. | – Асуудлыг зөв тодорхойлж, боломжит шийдлийг олдог,<br>– Асуудлыг шийдвэрлэхдээ тал бүрээс нь олон хувилбараар хардаг,<br>– Үр дүнтэй, цагаа олсон, амьдралд хэрэгжихүйц шийдвэр гаргадаг,<br>– Гаргасан шийдвэрийнхээ хүрээнд хариуцлага үүрдэг,<br>– Асуудлын шийдэл олох, гарц гаргалгаа гаргахдаа бодит байдлыг харгалзан, ёс зүйг баримталдаг,<br>– Шаардлагатай үед зоримог шийдвэр гаргадаг,<br>– Аливаа асуудлыг шийдвэрлэхдээ тухайн асуудалд хамаарал бүхий бүх талууд (байгууллагын дотор болон гадна)-ын оролцоог хангадаг,<br>– Өөрийн болон доод албан тушаалтны гаргасан шийдвэрт хариуцлага хүлээдэг,<br>– Гаргасан шийдвэрээ хэрэгжүүлэхэд манлайлан оролцдог. | – Оновчтой шийдвэр гаргах, зөвлөгөө өгөхдөө баримт материал, нотолгоо ашигладаг,<br>– Шийдвэрийн хүрээнд бий болох үр дагаврыг таамагладаг,<br>– Шинэ санаачилга ашиглан логиктой, ёс зүйтэй шийдэл гаргадаг,<br>– Ойлгомжгүй, төвөгтэй нөхцөл байдалд шийдэл гаргаж чаддаг,<br>– Өөрийн болон багийн гаргасан аливаа шийдвэрт хариуцлага хүлээдэг,<br>– Зөвшөөрөгдсөн тохиолдолд хатуу чиг шугамтай, шударгаар шийдвэр гаргах чаддаг,<br>– Харилцагч талуудтай хамтран ажиллахыг дэмждэг,<br>– Шаардлагатай нөхцөлд баримт, нотолгоонд үндэслэн гаргасан шийдвэрээ эргэн харж өөрчлөлт оруулдаг,<br>– Гаргасан шийдвэрээ хэрэгжүүлэхэд манлайлан оролцдог. |

# МАНЛАЙЛАХ ЧАДАМЖ

*Хүснэгт 6.*

<table>
<tr><td>Чадамжийн бүлэг</td><td colspan="4">Нийтлэг чадамж</td></tr>
<tr><td>Дэд чадамж</td><td colspan="4">Манлайлах</td></tr>
<tr><td>Чадамжийн тодорхойлолт</td><td colspan="4">Ажилтнууд урам зоригтой хичээнгүйлэн, өндөр бүтээмжтэй ажиллах, үнэнч шударгаар харилцах, нээлттэй, ил тод байх орчныг бий болгож улмаар бүх хүнд шударга, үнэнч хандаж ёс зүйн дүрмийг сурталчлан дагаж мөрдөх, өөрөөрөө үлгэрлэх замаар бусдад эергээр нөлөөлөх, Төрийн аудитын байгууллагын стратеги, бодлогын зорилгыг тодорхойлох, боловсруулах, хэрэгжүүлэх, биелэлтийг хангах харилцааны явцад байгууллага, албан хаагчид, иргэдийн дэмжлэг, оролцоог манлайлах чадвар юм.</td></tr>
<tr><td>Албан тушаал<br>Албан тушаалын ангилал</td><td>Аудитор<br>Төрийн аудитын түшээ</td><td>Ахлах аудитор<br>Төрийн аудитын ахлах түшээ</td><td>Аудитын менежер<br>Төрийн аудитын зөвлөх түшээ</td><td>Тэргүүлэх аудитор<br>Төрийн аудитын итгэмжит түшээ</td></tr>
<tr><td>Шалгуур үзүүлэлт</td><td>– Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн ёс зүйн дүрэм, үйлчилгээний стандартыг дагаж мөрддөг,<br>– Ажил сайжруулах санаачилга гаргадаг,<br>– Ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажилладаг,<br>– Хамтран ажиллахад нөхөрсөг, нээлттэй, тааламжтай сэтгэгдэл төрүүлдэг,<br>– Шударга бус байдал, ялгаварлан гадуурхалтыг бууруулахын төлөө ажилладаг,<br>– Үр дүнд төвлөрч ажилладаг,<br>– Хамт олноо дэмжиж тусалдаг,<br>– Өөрийн болон доод албан тушаалтнуудын үйлдэлд хариуцлага хүлээдэг,<br>– Өөрийгөө хөгжүүлэх боломжийг эрэлхийлдэг,<br>– Байгууллагаа болон өөрийгөө эергээр илэрхийлдэг.</td><td>– Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, олон талт байдлыг дагаж мөрддөг, дэмждэг,<br>– Ажил дээрээ өөрөөрөө үлгэрлэн манлайлдаг,<br>– Үр дүнтэй өөрчлөлт, шинэтгэлийг дэмжин хэрэгжүүлдэг,<br>– Бусдын урам зоригийг бадраадаг,<br>– Хүмүүстэй адил тэгш, шударга харилцдаг,<br>– Ажил сайжруулах санаа оноог эрэлхийлж, шинэ санаа гаргадаг,<br>– Бусдад хүндэтгэлтэй, шударга, адил тэгш ханддаг,<br>– Харилцааны явцад бат бэх, найдвартай хамт олон бүрдүүлж чаддаг,<br>– Байгууллагын давуу талыг бий болгох, сурталчлахад гол үүрэг гүйцэтгэдэг.</td><td>– Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн ес зүйн өндөр хэм хэмжээ, олон талт байдлыг, хөхүүлэн дэмжиж урамшуулдаг,<br>– Ажил үйлчилгээгээ сайжруулахыг нэн тэргүүнд тавьдаг,<br>– Ажил сайжруулах санааг эрэлхийлж, хувь нэмрээ оруулдаг,<br>– Өндөр эрсдэлтэй нөхцөл байдлыг үр дүнтэй удирдах чадвартай,<br>– Доод албан тушаалтнуудаа дэмжиж, урам зориг өгдөг,<br>– Байгууллагын хэрэгцээг хувийн ашиг сонирхлоос дээгүүр тавьдаг,<br>– Төрийн аудитын байгууллагын нэр төр, бахархлыг өөрөөрөө үлгэрлэн харуулдаг,<br>– Шударга бустай тэмцдэг, түүний сөрөг нөлөөллийг арилгадаг,<br>– Албан хаагчид, оролцогч талууд, хамтрагчидтай хүндэтгэлтэй, адил тэгш харилцдаг.</td><td>– Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн ёс зүйтэй манлайллыг үлгэрлэн харуулдаг,<br>– Байгууллагын дүр төрхийг эергээр илэрхийлэгч,<br>– Байгууллага, албан хаагчдыг чиглүүлэх алсын харааг тодорхойлж, сурталчилдаг,<br>– Байгууллага доторх муу соёлыг илрүүлж бууруулахад шийдэмгий ханддаг,<br>– Аливаа асуудал бэрхшээл тулгарахад уян хатан ханддаг,<br>– Үр ашигтай өөрчлөлт, шинэтгэл, инновацийн боломж руу байгууллагаа манлайлан дагуулдаг,<br>– Байгууллагын хэрэгцээг хувийн ашиг сонирхлоос дээгүүр тавьдаг,<br>– Төрийн аудитын байгууллагын нэр төр, бахархлыг өөрөөрөө үлгэрлэн харуулдаг,<br>– Албан хаагчид, оролцогч талууд, хамтрагчидтай хүндэтгэлтэй, адил тэгш харилцдаг.</td></tr>
</table>

# БАГААР АЖИЛЛАХ ЧАДАМЖ

*Хүснэгт 7.*

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Чадамжийн бүлэг** | **Нийтлэг чадамж** | | | |
| **Дэд чадамж** | **Багаар ажиллах** | | | |
| **Чадамжийн тодорхойлолт** | Мэдээлэл, санаа оноо, нөөц, дэмжлэгийг бусадтай хуваалцаж ажиллах, байгууллагын болон багийн нэгдмэл зорилгод хүрэхэд үр дүнтэй хамтран ажиллах чадвар юм. | | | |
| **Албан тушаал** | *Аудитор* | *Ахлах аудитор* | *Аудитын менежер* | *Тэргүүлэх аудитор* |
| **Албан тушаалын ангилал** | *Төрийн аудитын түшээ* | *Төрийн аудитын ахлах түшээ* | *Төрийн аудитын зөвлөх түшээ* | *Төрийн аудитын итгэмжит түшээ* |
| **Шалгуур үзүүлэлт** | – Нэгдмэл зорилтдоо амжилттай хүрэх хүсэл эрмэлзэлтэй байдаг,<br>– Мэдлэг, мэдээлэл, ур чадвараа хуваалцдаг,<br>– Итгэлцэл бүхий, ажил хэрэгч, нээлттэй харилцаа бий болгодог,<br>– Багийн сайн харилцаа, дотоод зохион байгуулалт, цаг ашиглалтад анхаардаг,<br>– Багийн бүх гишүүдийн санал санаачилгад нээлттэй ханддаг,<br>– Багт ирүүлсэн санал хүсэлтийг нээлттэй хүлээн авч, арга хэмжээ аван хариу өгдөг,<br>– Багийн ажилд манлайлан оролцдог,<br>– Хамтран ажиллагсдын тавьсан шаардлага, зөвлөгөөг хүлээн авдаг. | – Багийн ил тод, шударга зохион байгуулалт бий болгодог,<br>– Ажлын арга барилыг сайжруулахын төлөө багтай хамтран ажилладаг,<br>– Мэдлэг, мэдээлэл, ур чадвараа харамгүй, идэвхтэй хуваалцдаг,<br>– Хамт олны дотор харилцан биесээ дэмждэг, нэгэндээ итгэдэг, мэргэжлийн харилцааг бий болгодог,<br>– Ёс зүйг баримтлан ажилладаг,<br>– Нээлттэй, шударга орчныг бүрдүүлж итгэлцэл бий болгодог,<br>– Бие биеэ харилцан хүлээн зөвшөөрдөг, дэмждэг, хоорондоо уялдаа холбоотой ажилладаг орчныг бий болгоход хүмүүст эерэг нөлөө үзүүлдэг,<br>– Ажлын гүйцэтгэлийг сайжруулахын тулд багийн гишүүдийг дэмжин урам зориг өгч ажилладаг. | – Багийн ил тод, шударга зохион байгуулалт бий болгодог,<br>– Багтаа үнэнч, хариуцлагатай байдлыг бий болгодог,<br>– Чиглүүлж, дэмжлэг үзүүлдэг, харилцахад нээлттэй байдаг,<br>– Багийн өмнө хариуцлага хүлээдэг,<br>– Зорилтоо биелүүлэх нөөц боломж, ур чадвар багт байгаа эсэхийг анхаардаг,<br>– Багийн соёлыг тасралтгүй сайжруулахад дэмжлэг үзүүлдэг,<br>– Багийн ажилд анхаарал хандуулж идэвхтэй оролцдог,<br>– Багийн гишүүдийн өмнө нээлттэй, харилцахад амар хялбар байдаг,<br>– Бусад баг, оролцогч талуудтай хамтран ажиллах, түншлэхийг дэмждэг. | – Удирдагч гэж хүлээн зөвшөөрөгдөж хүндлэгддэг,<br>– Газар, нэгжийн соёлыг тасралтгүй сайжруулах үйл явцыг биечлэн таниулдаг,<br>– Багт зорилтоо биелүүлэх нөөц боломж, ур чадвар байгаа эсэхэд анхаарал хандуулдаг,<br>– Гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж буй чиг үүргийн бус хүчин зүйлсийг арилгадаг,<br>– Байгууллагын дотроос гарсан санал, өөр үзэл бодлыг нээлттэй хүлээн авдаг,<br>– Ажилтнууд ажил үүргээ сайн гүйцэтгэх мэдлэгтэй байгаа эсэх, тэдэнд ямар сургалт болон нэг арга хэрэгсэл шаардлагатай байгааг тодорхойлоход анхаардаг,<br>– Багийн амжилтад хүн бүрийн оруулж буй хувь нэмрийг мэддэг, үнэлдэг,<br>– Хэдийд ч уулзах/ харилцах боломжтой, нээлттэй байдаг,<br>– Олон талт болон адил тэгш байдлын ялгааг үнэлж, үйл ажиллагаандаа харгалзан манлайлдаг. |

# ХАРИЛЦААНЫ ЧАДАМЖ

*Хүснэгт 8.*

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Чадамжийн бүлэг** | **Нийтлэг чадамж** | | | |
| **Дэд чадамж** | **Харилцаа** | | | |
| **Чадамжийн тодорхойлолт** | Төрийн аудитын үндсэн чиг үүргээ чанартай гүйцэтгэхийн тулд байгууллагын гадна болон дотоод орчинд удирдлага, хамтран ажиллагсад, харилцагч талуудтай мэдээлэл солилцох, өөрийгөө илэрхийлэх үр дүнтэй харилцах чадвар юм. | | | |
| **Албан тушаал** | *Аудитор* | *Ахлах аудитор* | *Аудитын менежер* | *Тэргүүлэх аудитор* |
| **Албан тушаалын ангилал** | *Төрийн аудитын түшээ* | *Төрийн аудитын ахлах түшээ* | *Төрийн аудитын зөвлөх түшээ* | *Төрийн аудитын итгэмжит түшээ* |
| **Шалгуур үзүүлэлт** | – Аливаа төсөл, төлөвлөгөөг ойлгомжтой, товч, тодорхой, оновчтой боловсруулдаг,<br>– Бичмэл мэдээллийг логиктой, тодорхой танилцуулдаг,<br>– Аливаа хэлэлцүүлэг, зөвшилцөөнд идэвхтэй оролцож санал өгдөг,<br>– Мэдээлэл, харилцааны зөрүү байгаа бол түүнийг арилгахын төлөө ажилладаг,<br>– Эелдэг, товч бөгөөд тодорхой харилцдаг,<br>– Аливаа уулзалтыг харилцан мэдээлэл солилцох хэмжээнд зохион байгуулж, хөтөлж чаддаг,<br>– Харилцааны арга барилаа харилцагч талынхаа хэрэгцээнд нийцүүлэн тохируулж чаддаг,<br>– Бусдыг идэвхтэй сонсож чаддаг, солилцсон мэдээллээ харилцан ойлголцсон эсэхийг шалгадаг, | – Олон нийт, бусад төрийн байгууллагатай харилцах төлөвлөгөө гаргахад оролцох, уг төлөвлөгөөг эргэн харах, энэ ажлын хүрээнд багтаа дэмжлэг үзүүлдэг,<br>– Олон нийтэд хандсан мэдээ, мэдээллийг үнэн зөв, товч, тодорхой, тэдний хэрэгцээ шаардлагад нь нийцсэн байдлаар бичих чадвартай,<br>– Аливаа уулзалтыг харилцан мэдээлэл солилцох хэмжээнд зохион байгуулж, хөтөлж чаддаг,<br>– Харилцааны арга барил, хэв маягаа харилцагч талын хэрэгцээнд нийцүүлэн тохируулдаг,<br>– Ойлгомжтой харилцдаг, бусдыг сонсож, өөрийн ойлголтоо зөв эсэхийг шалгадаг,<br>– Байгууллагын дотор, эсвэл бусад этгээдтэй харилцахдаа шинэлэг арга барил ашигладаг, түүнийг сурталчилдаг,<br>– Идэвхтэй сонсох чадвартайгаа харуулдаг, | – Харилцааны хэм хэмжээ, стратеги, төлөвлөгөө боловсруулж хөгжүүлдэг, тэдгээрийн үр дүнг үнэлдэг,<br>– Амжилтад нөлөө үзүүлэх харилцааны сайн аргыг багтаа үзүүлэн таниулж, үлгэрлэн дагуулж ажилладаг,<br>– Уулзалт, ярилцлага зохион байгуулахдаа оролцоог бүрэн хангаж, тодорхой үр дүнд хүрдэг,<br>– Бусдыг идэвхтэй сонсож чаддаг, тухайн сэдэв, асуудлын агуулгыг харилцан зөв ойлголцсон эсэхийг магадлан баталгаажуулдаг,<br>– Шинэ технологи, инновацийг хэрэглэдэг, үр ашгийг нь таниулан сурталчилдаг,<br>– Байгууллагын газар, хэлтэс, алба доторх үр дүнтэй харилцааны үр чадварт ач холбогдол өгдөг, дэмждэг,<br>– Хэвлэл мэдээлэлтэй харилцах өндөр үр чадвар эзэмшсэн, | – Байгууллагын харилцааг стратегийн түвшинд удирдан зохион байгуулдаг,<br>– Байгууллагаа шилдэг байдлын үлгэр жишээ болгон харуулдаг,<br>– Мэтгэлцээний үед бусдад нөлөөлөх, ятган, үнэмшүүлэх чадвартай,<br>– Харилцааны үр нөлөөг үнэлж чаддаг,<br>– Байгууллага дотор хөндлөн болон босоо түвшинд харилцаа үүсгэх журам, дараалал бий болгодог,<br>– Оролцогч талуудын харилцааны хэрэгцээг зөв тодорхойлж, хариу арга хэмжээ авч чаддаг,<br>– Албан хаагчдын санал, хүсэлтэд тогтмол хариу өгч, арга хэмжээ авдаг,<br>– Хэвлэл мэдээлэлтэй харилцах өндөр ур чадвар эзэмшсэн,<br>– Байгууллагыг төлөөлөхдөө олон нийтэд эерэг, зөв дүр төрхийг бий |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | – Аливаа албан бичиг, тайлан мэдээг монгол хэлний дүрмийн болон найруулга зүйн алдаагүй боловсруулдаг. | тухайн сэдэв, асуудлын агуулгыг харилцан зөв ойлголцсон эсэхээ шалгаж баталгаажуулдаг,<br>– Аливаа албан бичиг, тайлан мэдээг монгол хэлний дүрмийн болон найруулга зүйн алдаагүй боловсруулдаг. | – Байгууллагыг төлөөлөхдөө олон нийтэд эерэг, зөв дүр төрх бий болгож чаддаг, түүнийг хадгалдаг,<br>– Аливаа албан бичиг, тайлан мэдээг монгол хэлний дүрмийн болон найруулга зүйн алдаагүй боловсруулдаг. | болгож чаддаг, түүнийг хадгалдаг,<br>– Аливаа албан бичиг, тайлан мэдээг монгол хэлний дүрмийн болон найруулга зүйн алдаагүй боловсруулдаг. |

# МЭРГЭЖЛИЙН БОЛОН САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГ

*Хүснэгт 9.*

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Чадамжийн бүлэг** | **Мэргэжлийн мэдлэг** | | | |
| **Дэд чадамж** | **Мэргэжлийн болон салбарын хууль, эрх зүйн мэдлэг** | | | |
| **Чадамжийн тодорхойлолт** | Аудит хийх чиг үүргийг гүйцэтгэхийн тулд нийгмийн бүхий л салбарын хүрээнд үнэлэлт дүгнэлт өгөх мэргэжлийн болон салбарын холбогдох хууль эрх зүйн актыг ашиглах чадвар юм. | | | |
| **Албан тушаал** | *Аудитор* | *Ахлах аудитор* | *Аудитын менежер* | *Тэргүүлэх аудитор* |
| **Албан тушаалын ангилал** | *Төрийн аудитын түшээ* | *Төрийн аудитын ахлах түшээ* | *Төрийн аудитын зөвлөх түшээ* | *Төрийн аудитын итгэмжит түшээ* |
| **Шалгуур үзүүлэлт** | – Төрийн аудитын болон мэргэжлийн хууль дүрэм журмын суурь мэдлэгтэй,<br>– Төрийн аудитын хууль, дүрэм журмын мэдлэгээ ажилдаа ашиглаж, дагаж мөрддөг,<br>– Ажил дээрээ болон сургалтаар дамжуулан хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх боломжийг идэвхтэй эрэлхийлдэг. | – Төрийн аудитын болон мэргэжлийн хууль дүрэм журмын өргөн мэдлэгтэй, ажилдаа ашиглаж, дагаж мөрддөг,<br>– Багийн гишүүдийг хууль эрх зүй, дүрэм журмыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх талаар чиглүүлж, зааварладаг,<br>– Мэргэжлийн болон салбарын хууль эрх зүйн мэдлэгээ тасралтгүй суралцах, хөгжих боломжийг эрэлхийлдэг,<br>– Багийн гишүүддээ тодорхой мэдлэгээ хуваалцаж, арга зүйн дэмжлэг үзүүлдэг. | – Төрийн аудитын болон мэргэжлийн хууль дүрэм журмын өргөн хүрээний, гүнзгий мэдлэгтэй, ажилдаа байнга ашиглаж, дагаж мөрддөг,<br>– Багийн гишүүдийг хууль эрх зүй, дүрэм журмыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх талаар чиглүүлж, зааварладаг,<br>– Ажил дээрээ болон сургалтаар дамжуулан хууль эрх зүйн мэдлэгээ тасралтгүй хөгжүүлдэг, суралцдаг,<br>– Хууль, эрх зүй, дүрэм журмын талаар багийн гишүүдэд мэдлэгээ хуваалцаж, чиглүүлж, арга зүйн дэмжлэг үзүүлдэг. | – Төрийн аудитын болон мэргэжлийн хууль дүрэм журмын өргөн хүрээний, гүнзгий мэдлэгтэй, ажилдаа байнга ашиглаж, дагаж мөрддөг,<br>– Ажил дээрээ болон сургалтаар дамжуулан сурч, хөгжих боломжийг идэвхтэй эрэлхийлдэг,<br>– Хууль эрх зүй, дүрэм журмын талаар нэгжийн бүх ажилтнуудыг сургаж, хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг, сургалт зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьдаг. |

# МЭРГЭЖЛИЙН СТАНДАРТЫН МЭДЛЭГ

*Хүснэгт 10.*

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Чадамжийн бүлэг** | **Мэргэжлийн мэдлэг** | | | |
| **Дэд чадамж** | **Мэргэжлийн стандартын мэдлэг** | | | |
| **Чадамжийн тодорхойлолт** | Хууль тогтоомжид заасан аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС болон түүнд нийцүүлэн боловсруулсан үндэсний стандарт, заавар, удирдамжийн мэдлэг, аудитын үйл ажиллагаанд ашиглах чадвар юм. | | | |
| **Албан тушаал** | *Аудитор* | *Ахлах аудитор* | *Аудитын менежер* | *Тэргүүлэх аудитор* |
| **Албан тушаалын ангилал** | *Төрийн аудитын түшээ* | *Төрийн аудитын ахлах түшээ* | *Төрийн аудитын зөвлөх түшээ* | *Төрийн аудитын итгэмжит түшээ* |
| **Шалгуур үзүүлэлт** | – АДБОУС болон түүнд нийцүүлэн боловсруулж батлагдсан үндэсний стандартуудын талаар суурь ойлголттой,<br>– Стандартын талаарх ойлголт, мэдлэгээ аудитын ажилдаа үр дүнтэй ашигладаг,<br>– Стандартуудын шаардлагуудыг аудитын ажилдаа тогтмол ашиглаж, мөрддөг. | – АДБОУС болон түүнд нийцүүлэн боловсруулж баталсан үндэсний стандартуудын талаар өргөн мэдлэгтэй,<br>– Стандартын талаарх ойлголт, мэдлэгээ аудитын ажилдаа байнга, тогтмол ашигладаг,<br>– Стандартын хэрхэн ашиглаж буйгаа ойлгомжтой тайлбарлаж чаддаг,<br>– Стандартуудыг аудитын ажилдаа хэрэглэхдээ мэргэжлийн үнэлэлт, дүгнэлт хийдэг. | – АДБОУС болон түүнд нийцүүлэн боловсруулж баталсан үндэсний стандартуудын талаар өргөн, гүнзгий мэдлэгтэй,<br>– Стандартын талаарх мэдлэгээ аудитын ажилдаа байнга, тогтмол ашигладаг, тасралтгүй хөгжүүлдэг,<br>– Стандартын хэрэглээг ойлгомжтой тайлбарладаг, багийн гишүүдийг чиглүүлж, аргазүйн дэмжлэг үзүүлдэг,<br>– Стандартын хэрэглээтэй холбоотой заавар аргачлалд сайжруулалт хийх, зөвлөмж боловсруулдаг. | – АДБОУС болон түүнд нийцүүлэн боловсруулж баталсан үндэсний стандартуудын талаар өргөн, гүнзгий мэдлэгтэй,<br>– Стандартын талаарх мэдлэгээ аудитын ажилдаа байнга, тогтмол ашигладаг, тасралтгүй хөгжүүлдэг,<br>– Стандартын хэрэглээг ойлгомжтой тайлбарладаг,<br>– Нэгжийн ажилчдыг сургах, чиглүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хяналт тавьдаг,<br>– Стандартын хэрэглээтэй холбоотой заавар аргачлалд сайжруулалт хийх, зөвлөмж боловсруулдаг. |

# МЭРГЭЖЛИЙН ГАДААД ХЭЛНИЙ ЧАДВАР

*Хүснэгт 11.*

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Чадамжийн бүлэг** | **Мэргэжлийн мэдлэг** | | | |
| **Дэд чадамж** | **Мэргэжлийн гадаад хэлний чадвар** | | | |
| **Чадамжийн тодорхойлолт** | Төрийн аудитын арга зүй, стандартын шинэчлэл, олон чиг хандлагад нийцсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвараа хөгжүүлж чадахуйц гадаад хэлний мэдлэгтэй байх чадвар юм. | | | |
| **Албан тушаал** | *Аудитор* | *Ахлах аудитор* | *Аудитын менежер* | *Тэргүүлэх аудитор* |
| **Албан тушаалын ангилал** | *Төрийн аудитын түшээ* | *Төрийн аудитын ахлах түшээ* | *Төрийн аудитын зөвлөх түшээ* | *Төрийн аудитын итгэмжит түшээ* |
| **Шалгуур үзүүлэлт** | – Гадаад хэл дээрх эх сурвалжаас мэргэжлийн мэдээллийг уншиж ойлгодог,<br>– Гадаад хэлний мэдлэгээ тасралтгүй сайжруулах, суралцах хүсэл эрмэлтэй. | – Гадаад хэл дээрх эх сурвалжаас мэргэжлийн мэдээллийг уншиж ойлгодог,<br>– Гадаад хэлний мэдлэгээ тасралтгүй сайжруулах, суралцах хүсэл эрмэлтэй<br>– Харилцагч талуудтай гадаад хэл дээр харилцан ярианы суурь түвшинд ойлголцдог,<br>– Гадаад хэлний мэдлэгээ тасралтгүй сайжруулах, суралцах хүсэл эрмэлзэлтэй. | – Гадаад хэл дээрх эх сурвалжаас мэргэжлийн мэдээллийг уншиж ойлгодог,<br>– Харилцагч талуудтай гадаад хэл дээр бичгээр мэдээлэл солилцож, харилцдаг,<br>– Харилцагч талуудтай гадаад хэл дээр дунд түвшинд харилцан ярилцаж, ойлголцдог,<br>– Гадаад хэлний мэдлэгээ тасралтгүй сайжруулах, суралцах хүсэл эрмэлзэлтэй. | – Гадаад хэл дээрх эх сурвалжаас мэргэжлийн мэдээллийг уншиж ойлгодог,<br>– Харилцагч талуудтай гадаад хэл дээр бичгээр мэдээлэл солилцож, харилцдаг,<br>– Харилцагч талуудтай гадаад хэл дээр ахисан түвшинд харилцан ярилцаж, ойлголцдог,<br>– Гадаад хэлний мэдлэгээ тасралтгүй сайжруулах, суралцах хүсэл эрмэлзэлтэй. |

# МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЧАДВАР

*Хүснэгт 12.*

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Чадамжийн бүлэг** | **Мэргэжлийн мэдлэг** | | | |
| **Дэд чадамж** | **Мэдээллийн технологийн чадвар** | | | |
| **Чадамжийн тодорхойлолт** | Орчин үеийн мэдээллийн технологийн орчинд ажиллах, аудитын үйл ажиллагаанд үр дүнтэй ашиглах чадвар юм. | | | |
| **Албан тушаал** | *Аудитор* | *Ахлах аудитор* | *Аудитын менежер* | *Тэргүүлэх аудитор* |
| **Албан тушаалын ангилал** | *Төрийн аудитын түшээ* | *Төрийн аудитын ахлах түшээ* | *Төрийн аудитын зөвлөх түшээ* | *Төрийн аудитын итгэмжит түшээ* |
| **Шалгуур үзүүлэлт** | – Ажлаа гүйцэтгэхдээ хэрэглээний програм хангамжийн багцыг аппликейшн түвшинд болон интернэт орчинд ашигладаг,<br>– Дотоод сүлжээний орчинд ажиллаж чаддаг,<br>– Оффис хэрэглээний тоног төхөөрөмжүүдийг хэрэглэдэг,<br>– Сошиал платформуудаар мэдээлэл солилцож ажиллах чадвартай,<br>– Орчин үеийн мэдээллийн технологийн мэдлэг, ур чадвараа хөгжүүлдэг, хүсэл эрмэлзэлтэй,<br>– Технологийн мэдлэгээ бусадтай хуваалцдаг,<br>– Кибер болон мэдээллийн аюулгүй байдлыг хангах мэдлэг, дадалтай,<br>– Ажлыг хөнгөвчлөх, бүтээмжийг дээшлүүлэх, үр дүнг сайжруулах технологийн шийдлүүдийг эрэлхийлдэг. | – Ажлаа гүйцэтгэхдээ хэрэглээний програм хангамжийн багцыг аппликейшн түвшинд болон интернэт орчинд ашигладаг,<br>– Дотоод сүлжээний орчинд ажиллаж чаддаг,<br>– Оффис хэрэглээний тоног төхөөрөмжүүдийг хэрэглэдэг,<br>– Сошиал платформуудаар мэдээлэл солилцож ажиллах чадвартай,<br>– Орчин үеийн мэдээллийн технологийн мэдлэг, ур чадвараа хөгжүүлдэг, хүсэл эрмэлзэлтэй,<br>– Технологийн мэдлэгээ бусадтай хуваалцдаг,<br>– Кибер болон мэдээллийн аюулгүй байдлыг хангах мэдлэг, дадалтай,<br>– Ажлыг хөнгөвчлөх, бүтээмжийг дээшлүүлэх, үр дүнг сайжруулах технологийн шийдлүүдийг эрэлхийлдэг. | – Ажлаа гүйцэтгэхдээ хэрэглээний програм хангамжийн багцыг аппликейшн түвшинд болон интернэт орчинд ашигладаг,<br>– Дотоод сүлжээний орчинд ажиллаж чаддаг,<br>– Оффис хэрэглээний тоног төхөөрөмжүүдийг хэрэглэдэг,<br>– Сошиал платформуудаар мэдээлэл солилцож ажиллах чадвартай,<br>– Орчин үеийн мэдээллийн технологийн мэдлэг, ур чадвараа хөгжүүлдэг, хүсэл эрмэлзэлтэй,<br>– Технологийн мэдлэгээ бусадтай хуваалцдаг,<br>– Кибер болон мэдээллийн аюулгүй байдлыг хангах мэдлэг, дадалтай,<br>– Ажлыг хөнгөвчлөх, бүтээмжийг дээшлүүлэх, үр дүнг сайжруулах технологийн шийдлүүдийг эрэлхийлдэг. | – Ажлаа гүйцэтгэхдээ хэрэглээний програм хангамжийн багцыг аппликейшн түвшинд болон интернэт орчинд ашигладаг,<br>– Дотоод сүлжээний орчинд ажиллаж чаддаг,<br>– Оффис хэрэглээний тоног төхөөрөмжүүдийг хэрэглэдэг,<br>– Сошиал платформуудаар мэдээлэл солилцож ажиллах чадвартай,<br>– Орчин үеийн мэдээллийн технологийн мэдлэг, ур чадвараа хөгжүүлэх, хүсэл эрмэлзлийг урамшуулдаг, сурч хөгжих нөхцөлийг бүрдүүлдэг,<br>– Кибер болон мэдээллийн аюулгүй байдлыг хангах мэдлэг, дадалтай,<br>– Ажлыг хөнгөвчлөх, бүтээмжийг дээшлүүлэх, үр дүнг сайжруулах технологийн шийдлүүдийг эрэлхийлдэг, дэмждэг. |

# АУДИТЫН СЭДЭВ ТОДОРХОЙЛОХ

*Хүснэгт 13.*

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Чадамжийн бүлэг** | **Мэргэжлийн чадвар** | | | |
| **Дэд чадамж** | **Аудитын сэдэв тодорхойлох** | | | |
| **Чадамжийн тодорхойлолт** | Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үнэ цэнэ нэмэх төрийн аудитыг гүйцэтгэхийн тулд ач холбогдолтой, чухал сэдвүүдийг тодорхойлох, сонгох чадвар юм. | | | |
| **Албан тушаал** | *Аудитор* | *Ахлах аудитор* | *Аудитын менежер* | *Тэргүүлэх аудитор* |
| **Албан тушаалын ангилал** | *Төрийн аудитын түшээ* | *Төрийн аудитын ахлах түшээ* | *Төрийн аудитын зөвлөх түшээ* | *Төрийн аудитын итгэмжит түшээ* |
| **Шалгуур үзүүлэлт** | – Төрийн аудитын байгууллагын үндсэн зорилго, бүрэн эрхэд хамаарах аудитын сэдэв сонгох, батлуулах процессыг мэддэг,<br>– Тухайн аудитын хэрэглэгчдэд үнэ цэнэ нэмэх, хамааралтай, ач холбогдолтой байж болох аудитын сэдэвт анхаарлаа хандуулдаг,<br>– Аудитын сэдвийг тодорхойлохын тулд урьдчилсан судалгаа, дүн шинжилгээ хийдэг. | – Төрийн аудитын байгууллагын үндсэн зорилго, бүрэн эрхэд хамаарах аудитын сэдэв сонгох, батлуулах процессыг сайн мэддэг,<br>– Төрийн аудитын байгууллагын жилийн болон урт хугацааны аудитын төлөвлөгөөнд тусгах аудитын сэдвийг сонгох шалгуур, горимыг тодорхойлж хэрэгжүүлдэг,<br>– Аудитын сэдвийн ач холбогдолтой, хамааралтай, иргэд, олон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн эсэхэд дүн шинжилгээ хийх, оновчтой сонголт хийх, тайлагнадаг. | – Төрийн аудитын байгууллагын үндсэн зорилго, бүрэн эрхэд хамаарах аудитын сэдэв сонгох, батлуулах процессыг сайн мэддэг,<br>– Төрийн аудитын байгууллагын жилийн болон урт хугацааны аудитын төлөвлөгөөнд тусгах аудитын сэдвийг сонгох шалгуур, горимыг тодорхойлж хэрэгжүүлдэг,<br>– Аудитын сэдвийн ач холбогдолтой, хамааралтай байдлыг харгалзан шалгуурын дагуу сонгож, эрэмбэлдэг,<br>– Аудитын сэдэв сонгох процессын талаар багийн гишүүдэд арга зүйн дэмжлэг үзүүлдэг. | – Төрийн аудитын байгууллагын үндсэн зорилго, бүрэн эрхэд хамаарах аудитын сэдэв сонгох, батлуулах процессыг сайн мэддэг,<br>– Төрийн аудитын байгууллагын жилийн болон урт хугацааны аудитын төлөвлөгөөнд тусгах аудитын сэдвийг сонгох шалгуур, горимыг тодорхойлж, хэрэгжүүлэхэд хяналт тавьдаг,<br>– Тодорхойлсон аудитын сэдвүүдийг нягтлан үзэж, тэдгээрийн ач холбогдол, хамаарал, аудит хийх боломжтой эсэхийг хянаж үзэх ба аудитын тайлангийн зорилтот хэрэглэгчдэд үнэ цэнийг нэмэх нэмэлт сэдвүүдийг санал болгодог,<br>– Аудитын сэдвийг батлуулах ажлыг хариуцан зохион байгуулдаг. |

# АУДИТЫГ ТӨЛӨВЛӨХ

*Хүснэгт 14.*

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Чадамжийн бүлэг** | **Мэргэжлийн чадвар** | | | |
| **Дэд чадамж** | **Аудитыг төлөвлөх** | | | |
| **Чадамжийн тодорхойлолт** | Төрийн аудитыг үр дүнтэй гүйцэтгэх орчин нөхцөлийг судалж, эрсдэлд суурилсан аудитыг төлөвлөх, аудитын цар хүрээ, хэрэгжүүлэх горим сорилыг тодорхойлох, нөөцийн төлөвлөлтийг оновчтой хийх чадвар юм. | | | |
| **Албан тушаал** | *Аудитор* | *Ахлах аудитор* | *Аудитын менежер* | *Тэргүүлэх аудитор* |
| **Албан тушаалын ангилал** | *Төрийн аудитын түшээ* | *Төрийн аудитын ахлах түшээ* | *Төрийн аудитын зөвлөх түшээ* | *Төрийн аудитын итгэмжит түшээ* |
| **Шалгуур үзүүлэлт** | – Төрийн санхүү, төсвийн хяналтын хүрээнд хийгдэх аудитын орчин нөхцөл, шалгагдагч этгээд/шалгах асуудлын талаарх өргөн хүрээний, гүнзгий ойлголт, мэдлэг олж авдаг,<br>– Мэдээлэл олж авахдаа олон сурвалжийг ашигладаг, мэдээллийн эх сурвалжийн найдвартай, үнэн зөв байдлыг шалгадаг,<br>– Эрсдэл, эрсдэлийн үнэлгээний талаар ойлголттой, эрсдэлийн үнэлгээний горимуудыг мэддэг,<br>– Аудитын материаллаг байдлын талаар ойлголттой, материаллаг байдлын түвшин тооцож, ашигладаг,<br>– Үнэлэгдсэн эрсдэлийг хүлээн зөвшөөрөгдөх түвшин хүртэл бууруулах | – Төрийн санхүү, төсвийн хяналтын хүрээнд хийгдэх аудитын орчин нөхцөл, шалгагдагч этгээд/шалгах асуудлын талаарх өргөн хүрээний, гүнзгий ойлголт, мэдлэг олж авдаг,<br>– Багийн гишүүд нэгдмэл ойлголттой эсэхийг баталгаажуулдаг,<br>– Мэдээлэл олж авахдаа олон сурвалжийг ашигладаг, мэдээллийн эх сурвалжийн найдвартай, үнэн зөв байдлыг шалгадаг,<br>– Эрсдэл, эрсдэлийн үнэлгээний талаар ойлголттой, эрсдэлийн үнэлгээний горимуудыг мэддэг, ашигладаг,<br>– Аудитын материаллаг байдлын талаар ойлголттой, материаллаг байдлын түвшин тооцож, ашигладаг,<br>– Үнэлэгдсэн эрсдэлийг хүлээн зөвшөөрөгдөх түвшин хүртэл бууруулах | – Төрийн санхүү, төсвийн хяналтын хүрээнд хийгдэх аудитын орчин нөхцөл, шалгагдагч этгээд/шалгах асуудлын талаарх өргөн хүрээний, гүнзгий ойлголт, мэдлэг олж авдаг,<br>– Мэдээлэл олж авахдаа олон сурвалжийг ашигладаг, мэдээллийн эх сурвалжийн найдвартай, үнэн зөв байдлыг шалгадаг,<br>– Эрсдэл, эрсдэлийн үнэлгээний талаар ойлголттой, эрсдэлийн үнэлгээний горимуудыг мэддэг, ашигладаг, багийн гишүүдэд арга зүйн зөвлөмж өгдөг,<br>– Аудитын материаллаг байдлын талаар ойлголттой, материаллаг байдлын түвшин тооцож, ашигладаг,<br>– Үнэлэгдсэн эрсдэлийг хүлээн зөвшөөрөгдөх | – Төрийн санхүү, төсвийн хяналтын хүрээнд хийгдэх аудитын орчин нөхцөл, шалгагдагч этгээд/шалгах асуудлын талаарх өргөн хүрээний, гүнзгий ойлголт, мэдлэг олж авдаг,<br>– Мэдээлэл олж авахдаа олон сурвалжийг ашигладаг, мэдээллийн эх сурвалжийн найдвартай, үнэн зөв байдлыг шалгадаг,<br>– Тодорхойлогдсон эрсдэлүүд, эрсдэлийн үнэлгээний үр дүнд хяналт тавьдаг,<br>– Үнэлэгдсэн эрсдэлийг хүлээн зөвшөөрөгдөх түвшин хүртэл бууруулах стратеги, нөөцийн төлөвлөлтийг хянаж, баталдаг,<br>– Тодорхойлсон аудитын материаллаг байдлыг хянах, шаардлагатай бол өөрчлөх зөвлөмж өгдөг,<br>– Хангалттай, зохистой нотлох зүйл олж авахын тулд холбогдох аудитын горим, сорилыг төлөвлөлт, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | стратеги, нөөцийн төлөвлөлтийг хийдэг,<br>– Хангалттай, зохистой нотлох зүйл олж авахын тулд холбогдох аудитын горим, сорилыг төлөвлөж, баримтжуулдаг. | стратеги, нөөцийн төлөвлөлтийг хийдэг,<br>– Хангалттай, зохистой нотлох зүйл олж авахын тулд холбогдох аудитын горим, сорилыг оновчтой төлөвлөж, баримтжуулдаг,<br>– Багийн гишүүдийн ойлголтыг баталгаажуулж, үйл ажиллагааг хянаж, чиглүүлж, зөвлөдөг. | түвшин хүртэл бууруулах стратеги, нөөцийн төлөвлөлтийг хийдэг,<br>– Хангалттай, зохистой нотлох зүйл олж авахын тулд холбогдох аудитын горим, сорилыг оновчтой төлөвлөж, баримтжуулдаг. | баримтжуулалтын зохистой, хамааралтай байдлыг хянаж, баталгаажуулдаг. |

## АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭХ

*Хүснэгт 15.*

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Чадамжийн бүлэг** | **Мэргэжлийн чадвар** | | | |
| **Дэд чадамж** | **Аудитыг гүйцэтгэх** | | | |
| **Чадамжийн тодорхойлолт** | Гүйцэтгэж буй аудитын үр дүнгийн талаар үнэн зөв, бодитой дүгнэлт, зөвлөмж бэлтгэхийн тулд холбогдох аудитын горим сорилыг хэрэгжүүлэх замаар нотлох зүйл олж авах, хэрэгжүүлсэн горим болон олж авсан нотлох зүйлсийн хангалттай, зохистой байдалд дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг зохих ёсоор баримтжуулах чадвар юм. | | | |
| **Албан тушаал** | *Аудитор* | *Ахлах аудитор* | *Аудитын менежер* | *Тэргүүлэх аудитор* |
| **Албан тушаалын ангилал** | *Төрийн аудитын түшээ* | *Төрийн аудитын ахлах түшээ* | *Төрийн аудитын зөвлөх түшээ* | *Төрийн аудитын итгэмжит түшээ* |
| **Шалгуур үзүүлэлт** | – Хангалттай, зохистой нотлох зүйлийн мөн чанар, шинж чанарыг ойлгож, мэддэг,<br>– Аудитын нотолгоо цуглуулах арга, техникүүд (ярилцлага, асуулга судалгаа, ажиглалт, баримт бичгийн шалгалт гэх мэт)-ийг мэддэг,<br>– Аудитын хөтөлбөрт тусгагдсан аудитын горим сорилуудыг хэрэгжүүлэх замаар хангалттай, зохистой нотлох зүйл олж авдаг, нотолгоо цуглуулах арга техникүүдийг ашигладаг,<br>– Аудитын түүвэр, түүврийн мөн чанар, түүвэрлэх арга техникүүдийг мэддэг,<br>– Олж авсан нотолгоо, цуглуулсан өгөгдөл, мэдээлэлд дүн шинжилгээ хийх арга, шинжилгээний процессын талаар ойлголттой,<br>– Цуглуулсан мэдээлэл, өгөгдлийг ангилж, дүн шинжилгээ хийдэг, | – Хангалттай, зохистой нотлох зүйлийн мөн чанар, шинж чанарыг ойлгож, мэддэг,<br>– Хангалттай, зохистой нотолгоо олж авахын тулд өөр өөр эх сурвалжаас нотолгоо олж авдаг ба зохистой нотолгоо цуглуулах арга, техникүүд ашигладаг,<br>– Аудитын төлөвлөлтийн явцад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилыг хэрэгжүүлдэг, зохистой байдлыг хянаж үздэг,<br>– Аудитын түүвэр, түүврийн мөн чанар, түүвэрлэх арга техникүүдийг мэддэг, түүврийн аргыг хэээз, хэрхэн хэрэглэхээ мэддэг, ашигладаг,<br>– Аудитын зорилго, асуулт болон шалгуурт хариулахын тулд цуглуулсан мэдээлэл, нотлох зүйлийн хангалттай, зохистой байдалд дүн шинжилгээ хийдэг, дүн | – Хангалттай, зохистой нотлох зүйлийн мөн чанар, шинж чанарыг ойлгож, мэддэг,<br>– Хангалттай, зохистой нотолгоо олж авахын тулд өөр өөр эх сурвалжаас нотолгоо олж авдаг ба зохистой нотолгоо цуглуулах арга, техникүүд ашигладаг,<br>– Аудитын төлөвлөлтийн явцад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилыг хэрэгжүүлдэг, зохистой байдлыг хянаж үздэг,<br>– Аудитын төлөвлөгөө, горимын хэрэгжилтэд хяналт тавьдаг,<br>– Аудитын түүвэр, түүврийн мөн чанар, түүвэрлэх арга техникүүдийг мэддэг, түүврийн аргыг хэээз, хэрхэн хэрэглэхээ мэддэг, хэрхэн ашиглах талаар аргазүйн зөвлөмж өгдөг, чиглүүлдэг,<br>– Аудитын зорилго, асуулт болон шалгуурт хариулахын тулд | – Хангалттай, зохистой нотлох зүйлийн мөн чанар, шинж чанарыг ойлгож, мэддэг,<br>– Нотлох зүйлийн хангалттай, зохистой, иж бүрэн байдлыг хянаж үздэг,<br>– Аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг удирдан зохион байгуулж, хяналт тавьдаг,<br>– Аудитын төлөвлөгөө, горим сорилыг хэрэгжилт, үр дүнг хянаж үздэг, мэргэжлийн үнэлэлт дүгнэлт гаргадаг,<br>– Багийн болон нэгжийн гишүүдэд аудитын гүйцэтгэлийн үйл явцын талаар арга зүйн зөвлөмж өгдөг, чиглүүлдэг, хяналт тавьдаг. |

| | | |
|---|---|---|
| – Аудитын явцад олж авсан нотлох зүйл, хэрэгжүүлсэн горим сорилыг баримтжуулах, ажлын баримтын талаар зохих ойлголттой,<br>– Өөрийн гүйцэтгэсэн ажлыг батлагдсан стандарт, заавар, аргачлалын дагуу баримтжуулдаг. | шинжилгээний аргуудыг ашигладаг,<br>– Багийн гишүүдэд аудитын гүйцэтгэлийг хянаж, чиглүүлэх, аргазүйн зөвлөмж өгдөг,<br>– Өөрийн болон багийн гүйцэтгэсэн ажлыг батлагдсан стандарт, заавар, аргачлалын дагуу баримтжуулдаг, арга зүйн зөвлөмж өгдөг, чиглүүлдэг. | цуглуулсан мэдээлэл, нотлох зүйлийн хангалттай, зохистой байдалд дүн шинжилгээ хийдэг, дүн шинжилгээний аргуудыг зохистой байдлаар сонгож ашигладаг,<br>– Цуглуулсан мэдээлэл, нотлох зүйлийн талаар дүн шинжилгээний үр дүнг нэгтгэн дүгнэж, мэргэжлийн үнэлэлт дүгнэлт гаргадаг,<br>– Багийн гишүүдэд аудитын гүйцэтгэлийг хянаж, чиглүүлэх, арга зүйн зөвлөмж өгдөг,<br>– Өөрийн болон багийн гүйцэтгэсэн ажлыг батлагдсан стандарт, заавар, аргачлалын дагуу баримтжуулдаг, арга зүйн зөвлөмж өгдөг, чиглүүлдэг. |

# АУДИТЫН ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ

*Хүснэгт 16.*

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Чадамжийн бүлэг** | **Мэргэжлийн чадвар** | | | |
| **Дэд чадамж** | **Аудитын үр дүнг тайлагнах** | | | |
| **Чадамжийн тодорхойлолт** | Аудитын үр дүнг холбогдох аудитын стандартын шаардлагад нийцүүлэн бодитой, үндэслэлтэй, иж бүрэн, нягт нямбай, ойлгомжтой, батлагдсан загвар, стандартын дагуу бэлтгэж, харилцагч талуудад тайлагнах чадвар юм. | | | |
| **Албан тушаал** | *Аудитор* | *Ахлах аудитор* | *Аудитын менежер* | *Тэргүүлэх аудитор* |
| **Албан тушаалын ангилал** | *Төрийн аудитын түшээ* | *Төрийн аудитын ахлах түшээ* | *Төрийн аудитын зөвлөх түшээ* | *Төрийн аудитын итгэмжит түшээ* |
| **Шалгуур үзүүлэлт** | – Аудитын үр дүнг, нотлох зүйлийн хангалтай, зохистой байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, зохистой шийдвэр гаргадаг,<br>– Аудитын үр дүнг аудитын зорилгод нийцүүлэн, тогтсон загвар, стандартын дагуу боловсруулдаг,<br>– Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил, залилангийн үнэн зөв, шударгаар тайлагнадаг,<br>– Тодорхой, ул үндэслэлтэй, логиктой, үнэ цэнэ нэмсэн, асуудал ба сул талуудын шалтгааныг арилгах зөвлөмж боловсруулдаг,<br>– Аудитын үр дүнг дээд албан тушаалтан болон харилцагч талуудад үр дүнтэй, зохих хэлбэрээр тайлагнадаг. | – Аудитын үр дүнг, нотлох зүйлийн хангалтай, зохистой байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, зохистой шийдвэр гаргадаг,<br>– Аудитын үр дүнг аудитын зорилгод нийцүүлэн, тогтсон загвар, стандартын дагуу боловсруулдаг,<br>– Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил, залиланг үнэн зөв, шударгаар тайлагнадаг,<br>– Тодорхой, ул үндэслэлтэй, логиктой, үнэ цэнэ нэмсэн, асуудал ба сул талуудын шалтгааныг арилгах зөвлөмж боловсруулдаг,<br>– Аудитын үр дүнг дээд албан тушаалтан болон харилцагч талуудад үр дүнтэй, зохих хэлбэрээр тайлагнадаг,<br>– Багийн гишүүдийн ойлголт, дүгнэлттэй танилцаж, хянаж, чиглүүлдэг. | – Аудитын үр дүнг, нотлох зүйлийн хангалтай, зохистой байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, зохистой шийдвэр гаргадаг,<br>– Аудитын үр дүнг аудитын зорилгод нийцүүлэн, тогтсон загвар, стандартын дагуу боловсруулдаг,<br>– Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил, залиланг үнэн зөв, шударгаар тайлагнадаг,<br>– Тодорхой, ул үндэслэлтэй, логиктой, үнэ цэнэ нэмсэн, асуудал ба сул талуудын шалтгааныг арилгах зөвлөмж боловсруулдаг,<br>– Аудитын үр дүнг дээд албан тушаалтан болон харилцагч талуудад үр дүнтэй, зохих хэлбэрээр тайлагнадаг,<br>– Багийн гишүүдийн ойлголт, дүгнэлттэй танилцаж, хянаж, чиглүүлдэг. | – Аудитын үр дүнг, нотлох зүйлийн хангалтай, зохистой байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, зохистой шийдвэр гаргадаг,<br>– Аудитын үр дүнг аудитын зорилгод нийцүүлэн, тогтсон загвар, стандартын дагуу боловсруулах, хяналт тавьдаг,<br>– Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил, залиланг үнэн зөв, шударгаар тайлагнадаг,<br>– Тодорхой, ул үндэслэлтэй, логиктой, үнэ цэнэ нэмсэн, асуудал ба сул талуудын шалтгааныг арилгах зөвлөмж боловсруулдаг,<br>– Аудитын үр дүнг дээд албан тушаалтан болон харилцагч талуудад үр дүнтэй, зохих хэлбэрээр тайлагнадаг,<br>– Газар, нэгжийн албан хаагчдын ойлголт, дүгнэлттэй танилцаж, хянаж, чиглүүлдэг. |

# АУДИТЫН МӨРӨӨР ХЯНАЛТ ТАВИХ

*Хүснэгт 17.*

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Чадамжийн бүлэг** | **Мэргэжлийн чадвар** | | | |
| **Дэд чадамж** | **Аудитын мөрөөр хяналт тавих** | | | |
| **Чадамжийн тодорхойлолт** | Харилцагч талуудтай хамт аудитын үр дүнг эргэн харж, хяналт тавих төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх, аудитаас гаргасан зөвлөмж, шийдвэрийн хэрэгжилтийг хянах чадвар юм. | | | |
| **Албан тушаал** | *Аудитор* | *Ахлах аудитор* | *Аудитын менежер* | *Тэргүүлэх аудитор* |
| **Албан тушаалын ангилал** | *Төрийн аудитын түшээ* | *Төрийн аудитын ахлах түшээ* | *Төрийн аудитын зөвлөх түшээ* | *Төрийн аудитын итгэмжит түшээ* |
| **Шалгуур үзүүлэлт** | – Аудитын мөрөөр хяналт тавих ажлыг гүйцэтгэхийн тулд холбогдох бодлого, горим, журам зааврыг мэддэг,<br>– Аудитын үр дүн, зөвлөмжийн дагуу харилцагч талуудтай хамтран хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлдэг,<br>– Аудитаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг үнэлж, үр дүнг дээд шатны албан тушаалтан болон харилцагч талуудад тайлагнадаг. | – Аудитын мөрөөр хяналт шалгалтыг гүйцэтгэхийн тулд холбогдох бодлого, горим, журам зааврыг өргөн хүрээнд мэддэг,<br>– Багийн гишүүдийг чиглүүлж, арга зүйн зөвлөмж өгдөг,<br>– Аудитын үр дүн, зөвлөмжийн дагуу харилцагч талуудтай хамтран хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлдэг,<br>– Аудитаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг үнэлж, үр дүнг дээд шатны албан тушаалтан болон харилцагч талуудад тайлагнадаг. | – Аудитын мөрөөр хяналт шалгалтыг гүйцэтгэхийн тулд холбогдох бодлого, горим, журам зааврыг өргөн хүрээнд мэддэг,<br>– Багийн гишүүдийг чиглүүлж, арга зүйн зөвлөмж өгдөг,<br>– Аудитын үр дүн, дүгнэлтийг дэмжих нотолгооны зохистой, хангалттай байдлыг үнэлж, дүгнэн зохих шийдвэрийг гаргадаг,<br>– Аудитаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг үнэлж, мөрөөр хяналт шалгалтын тайлан бэлтгэж, харилцагч талуудад үр дүнг дээд шатны албан тушаалтан болон харилцагч талуудад тайлагнадаг. | – Аудитын мөрөөр хяналт шалгалтыг гүйцэтгэхийн тулд холбогдох бодлого, горим, журам зааврыг өргөн хүрээнд мэддэг,<br>– Багийн гишүүдийг чиглүүлж, арга зүйн зөвлөмж өгдөг,<br>– Аудитын үр дүнд гаргасан шийдвэрийн зохистой байдлыг хянаж, сайжруулах зөвлөмж өгдөг,<br>– Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн үр нөлөөг цогцоор нь судалж, дүн шинжилгээ хийж, хянадаг,<br>– Мөрөөр хяналт шалгалтын үр дүнд шалгагдагч байгууллагын зөвлөмжийн хэрэгжилтэд үргэлжлүүлэн хяналт тавих эсвэл шинээр аудитын аудитын ажлыг эхлүүлэх эсэх шийдвэр гаргадаг. |

# АУДИТЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ

*Хүснэгт 18.*

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Чадамжийн бүлэг** | **Мэргэжлийн чадвар** | | | |
| **Дэд чадамж** | **Аудитын чанарын хяналт хийх** | | | |
| **Чадамжийн тодорхойлолт** | Чанарын хяналт хийх зорилгоор холбогдох стандарт, дүрэм журам зохистой хэрэгжсэн гэдгийг үнэлэх, аудитын хэрэгжүүлсэн горим, гүйцэтгэлд үнэлэлт дүгнэлт өгөх, сайжруулах зөвлөмж өгөх чадвар юм. | | | |
| **Албан тушаал** | *Аудитор* | *Ахлах аудитор* | *Аудитын менежер* | *Тэргүүлэх аудитор* |
| **Албан тушаалын ангилал** | *Төрийн аудитын түшээ* | *Төрийн аудитын ахлах түшээ* | *Төрийн аудитын зөвлөх түшээ* | *Төрийн аудитын итгэмжит түшээ* |
| **Шалгуур үзүүлэлт** | – Төрийн аудитын байгууллагын чанарын хяналтын тогтолцоо нь аудитын ажлыг чанартай гүйцэтгэхэд чиглэгдсэн, үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэхийг шалгах чанарын хяналтын зорилгыг ойлгодог,<br>– Чанарын хяналтын бодлого, горимыг мэддэг,<br>– Аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлсэн аудитын ажилд анхан шатны чанарын хяналт хийх журам, зааврыг мэддэг. | – Төрийн аудитын байгууллагын чанарын хяналтын тогтолцоо нь аудитын ажлыг чанартай гүйцэтгэхэд чиглэгдсэн, үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэхийг шалгах чанарын хяналтын зорилгыг мэддэг,<br>– Чанарын хяналтын бодлого, горимыг мэддэг, хэрэгжүүлдэг,<br>– Аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлсэн аудитын ажилд анхан шатны чанарын хяналт хийх журам, зааврыг мэддэг, хэрэгжүүлдэг,<br>– Тухайн аудитын ажил нь холбогдох стандарт, дүрэм журмын шаардлагыг хангасан эсэхийг чанарын хяналтын журмын дагуу хэрэгжүүлдэг,<br>– Багийн гишүүдийг чиглүүлэх, арга зүйн зөвлөмж өгдөг. | – Төрийн аудитын байгууллагын чанарын хяналтын тогтолцоо нь аудитын ажлыг чанартай гүйцэтгэхэд чиглэгдсэн, үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэхийг шалгах чанарын хяналтын зорилгыг мэддэг,<br>– Чанарын хяналтын бодлого, горимыг мэддэг, хэрэгжүүлдэг,<br>– Аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлсэн аудитын ажилд анхан шатны чанарын хяналт хийх журам, зааврыг мэддэг, хэрэгжүүлдэг,<br>– Тухайн аудитын ажил нь холбогдох стандарт, дүрэм журмын шаардлагыг хангасан эсэхийг чанарын хяналтын журмын дагуу хэрэгжүүлдэг,<br>– Багийн гишүүдийг чиглүүлэх, арга зүйн зөвлөмж өгдөг. | – Төрийн аудитын байгууллагын чанарын хяналтын тогтолцоо нь аудитын ажлыг чанартай гүйцэтгэхэд чиглэгдсэн, үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэхийг шалгах чанарын хяналтын зорилгыг мэддэг,<br>– Чанарын хяналтын бодлого, горимыг мэддэг, хэрэгжүүлдэг,<br>– Аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлсэн аудитын ажилд чанарын хяналт хийх журам, зааврыг мэддэг, чанарын хяналт хийх ажлыг зохион байгуулж, удирддаг,<br>– Тухайн аудитын ажил нь холбогдох стандарт, дүрэм журмын шаардлагыг хангасан эсэхийг чанарын хяналтын журмын дагуу хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулдаг, хянадаг. |

-o O o